



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.31

№

718

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯН-АДАРГА
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Баян-Адарга сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол

Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Баян-Адарга сумын Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баян-Адарга сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Д.ОЮУНТУЯА

Ц.БИЛЭГСАЙХАН

Ц.ХАТАНБОЛД

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-АДАРГА СУМЫН МАН-ЫН 2024 ОНЫ
ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

АГУУЛГА

1. Эдийн засгийн өсөлтийг өрх бүрт хүргэх хүний хөгжлийн бодлого
 - a. Орон сууц
 - b. Эрүүл мэнд
 - c. Боловсрол
 - d. Халамж, хөдөлмөр эрхлэлт
 - e. Үндэсний бахархал, өв соёл, спорт
 - f. Хүүхэд гэр бүлийн хөгжил
2. Эдийн засгийн бодлого
 - a. Хөдөө аж ахуй
 - b. Аялал жуулчлал
 - c. Эрчим хүчний төсөл
 - d. Авто зам
3. Ногоон хөгжлийн бодлого
4. Иргэдийн оролцоонд тулгуурласан засаглалын бодлого
5. Орон нутгийн хөгжлийн бодлого



1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орон сууц

- 1.1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хямд өртөгтэй орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллана. Орон сууцны барилга барих газрын асуудлыг ИТХ-р хэлэлцэж богино хугацаанд шийдвэрлэнэ.
- 1.1.2. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээл олгох боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- 1.1.3. Зорилтот бүлэг /төрийн албан хаагч, залуу гэр бүл/-д чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэнэ.

1.2. Эрүүл мэнд

- 1.2.1. Орон нутагт дутагдалтай байгаа эмч, мэргэжилтнийг бэлтгэх бодлогыг тодорхойлж, тэднийг чадавхжуулах, хүний нөөцийн нийгмийн баталгааг ханган ажиллана.
- 1.2.2. Эрүүл мэндийн үзлэгийг тасралтгүй үргэлжлүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.
- 1.2.3. Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношилж, эмчлэх чиглэлээр гадаадын эмнэлгүүдтэй гэрээ байгуулж, хамтарч ажиллан сумынхаа иргэдэд ээлтэй тогтолцоог бий болгоно.
- 1.2.4. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 1.2.5. Эрүүл мэндийн байгууллагыг дутагдалтай байгаа тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.

1.3. Боловсрол

- 1.3.1. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ
- 1.3.2. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
- 1.3.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлнэ
- 1.3.4. Цэцэрлэг, сургуулийн орчныг камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ
- 1.3.5. Цэцэрлэгийн гаднах орчин, тоглоомын талбайг шинэчлэн тохижуулна.
- 1.3.6. Хүүхэд-Хөгжил хөдөлмөр зуслангийн үйл ажиллагааг эхлүүлж, тохижилтын ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.3.7. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор тэргүүлсэн болон чухал шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутан суралцагсадтай хамтран ажиллах гэрээ байгуулж, тэтгэлэгт болон бусад хөтөлбөрүүдэд хамруулна.

1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт

- 1.4.1. Иргэдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг бий



- болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгож, ядуурлын түвшинг бууруулна
- 1.4.2. Төрийн байгууллагуудын нэрэмжит Ахмадын өдөрлөгийг уламжлал болгон явуулна.
 - 1.4.3. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлсэн тохируулгатай ажлын байр бий болгосон жишиг байгууллага, аж ахуйн нэгжийг жил бүр шалгаруулна
 - 1.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгэмд дасан зохицох, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдах, бие даан амьдрах, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Хүний хөгжлийн төв”- ийг ажиллуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт
 - 1.5.1. Соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулна
 - 1.5.2. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын аймаг, бүс, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.
 - 1.5.3. Спорт заал барьж, ашиглалтанд оруулна
 - 1.5.4. Үндэсний спортыг жигд хөгжүүлэхэд холбогдох арга хэмжээг авч ажиллана.
 - 1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил
 - 1.6.1. Гэр бүл, хүүхдэд сургалт хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг сургалтын төвтэй болно
 - 1.6.2. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хөдөө аж ахуй
 - 2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлнэ.
 - 2.1.2. Малжуулах төслийг хэрэгжүүлж, залуу малчдыг дэмжиж ажиллана.
 - 2.1.3. Бэлчээрийг зохистой ашиглах, усан хангамжийг нэмэгдүүлж малчдын саналд тулгуурлан худаг гаргах, сэргээн засварлах, булгийн эхийг хашиж хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ.
 - 2.1.4. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг сумандаа хэрэгжүүлнэ
 - 2.1.5. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.
 - 2.1.6. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална
- 2.2. Аялал жуулчлал
 - 2.2.1. Аялал жуулчлалын гол маршрут дагуух сумдад отоглох цэгийг Дадал, Биндэр, Баян-Адарга, Батширээт, Норовлин, Батноров сумдад бий болгоно.
 - 2.2.2. Баян-Адрага сумын Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээлэлийн төвийг барьж байгуулна
 - 2.2.3. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.



- 2.3. Эрчим хүчний төсөл
- 2.3.1. Зүүн бүсэд 100 доошгүй МВА чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд бий болгох талаар Хэрлэн, Онон голуудад бага чадлын усан цахилгааны станцын боломж судлах, Салхины хурд эрчимжилтийн судалгаа хийнэ.
- 2.3.2. Сумдын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ
- 2.3.3. Адарга, Сайхан багийн төвүүдийг үе шаттайгаар цахилгааны эх үүсвэртэй болгоно
- 2.3.4. Сумын төвд шинээр газар эзэмших, өмчлөх эрх авч кадастрын зураглалд орсон газруудад цахилгааны шугам тавих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ

2.4. Авто зам

- 2.4.1. Биндэр сумаас Баян-Адрага чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна.
- 2.4.2. Сумын төвд хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулна

3. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1. Хог хаягдлын зориулалтын III зэргийн ландфил байгууламжтай болно.
- 3.2. Хог хаягдал ангилан ялгах цехийг байгуулна
- 3.3. “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ОУБ-тай хамтарч 20000 га газрыг ойжуулах арга хэижээг үе шаттайгаар зохион байгуулна.
- 3.4. Сумын төвийн ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, ногоон зурвасуудыг шинээр байгуулж, ногоон байгууламжуудын ашиглалт, үйлчилгээг сайжруулна.

4. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1. Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно
- 4.2. Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 4.3. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтална.
- 4.4. Тендер сонгон шалгаруулалт, газар олголт, орон нутгийн эд хөрөнгийн дуудлага худалдааг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна
- 4.5. Орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх, ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 4.6. Сумын төвд камержуулалтын системийг бүрэн нэвтрүүлнэ
- 4.7. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, иргэд, бизнест төвөггүй, хялбар үйлчилгээг үзүүлнэ.

5. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1. Баян-Адрага сумын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно
- 5.2. Баян-Адарга сумын үүрэн телефоны сүлжээг өргөтгөнө



- 5.3. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын тогтолцоог хөгжүүлж, алслагдсан бүс нутаг, аймгийн төв, сумдад томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 5.4. Сумын цэвэр усны худгийг ухаалаг системд үе шаттайгаар шилжүүлж, ашиглалтыг сайжруулна.
- 5.5. “Орон нутгийн хөгжлийн сан”, “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас зарцуулагдах хөрөнгөнөөс төсөл арга хэмжээ, зээл олгохдоо багийн иргэдийн нийтийн хурлаар төслүүдийг хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоог бий болгоно.
- 5.6. “Архидалтгүй-Баян-Адаргачууд” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.7. Төсвийн ил тод байдлыг хангаж, сумын төсвөөс зарцуулах хөрөнгийг бүх шатны байгууллагаас иргэдэд мэдээллэх, тайлагнах, “Ил тод төсөв” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- 5.8. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг зөрчлийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлж, мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор “Хишиг өдөр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- 5.9. Суманд шаардлагатай эмч, багш мэргэжилтэй боловсон хүчинг гурвалсан гэрээний үндсэн дээр ажиллуулах шинэ тогтолцоог бий болгоно.
- 5.10. “Гамшгаас хамгаалах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.11. БНСУ-ын аймаг, сумдын засаг захиргааны нэгжийн хооронд хамтын ажиллагааг эхлүүлнэ.

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын МАН-ын хороо

